



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 609

Улаанбаатар хот

Г Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.


2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга 3.Энхболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашины ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;


2.2.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлagnах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны дугаар сарын 05 өдрийн
дугаар тогтоолын хавсралт



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ АВТОМАШИНЫ
АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

Д/д	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хот доторх ажлын суудлын автомашин	1
2		Хот доторх ажлын автомашин /микро/	1
Нийт автомашин			2